


**“Тариалангийн талбайн
хөрсний үржил шимийг
хамгаалах чиглэлээр
баримталж буй хууль эрх
зүй, бодлого”**

Улаанбаатар хот 2015 он

Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга Ц.Болорчулуун

Хууль эрх зүйн баримт бичгүүд

- Тариалангийн тухай хууль, /2004 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр/
- Газрын тухай хууль, /2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр/
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, /2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр/
- Газрын төлбөрийн тухай хууль, /1997 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр/
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, /2002 оны 06 дугаар сарын 27-ны өдөр/




Журам, бодлогын баримт бичгүүд

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, /2003, 29-р тогтоол/
- “Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал халдваргүйтгэлийн бодисыг ашиглах, турших журам” /2009-3-18-ны өдрийн 63/67/87 тогтоол/
- “Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бордооны аюулгүй байдалд тавих шаардлага” журам /2013 он А/105 тушаал/

Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд

(Тариалангийн газрын хөрсийг хамгаалах)



18 дугаар зүйл. Тариалангийн үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэлээр

- ▶ 18.1. Үр тарианы үйлдвэрлэлд хөрс хамгаалах тэг болон цомхотгосон технологийг ашиглана.
- ▶ 18.3. Тариалангийн үйлдвэрлэлийн техник нь хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгах, нөөц хэмнэсэн, хүн ажиллахад таатай, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах шаардлагыг хангасан байна.
- ▶ 18.4. Атар болон атаршсан газрыг эхний удаа тариалангийн эргэлтэд оруулахаас бусад тохиолдолд үр тарианы үйлдвэрлэлд газрын хөрсийг хөмрүүлж хагалах техник, технологи ашиглахыг хориглоно.

Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын талаар

- ▶ 26.1.Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарыг таримал ургамлын өсөлт, хөгжилтийг хангах үржил шим /ялзмаг/, шим тэжээлийн бодис, хөрсний элэгдэл, эвдрэлийн зэргийн үзүүлэлтээр тогтооно.
- ▶ 26.2.Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг агрохими, агрофизикийн шинжилгээгээр тодорхойлно.
- ▶ 26.7.Агрохими, агрофизикийн шинжилгээг 5 жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ.

Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарт тавих хяналт

- ▶ 27.1.Хөрсний төлөв байдалд тавих хяналтыг тариалангийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.
- ▶ 27.2.Агрохими, агрофизикийн шинжилгээний дүнгээр хөрсний төлөв байдал, чанарыг өмнөх шинжилгээний дүнгээс дордуулсан бол сайжруулах тодорхой арга хэмжээ авах талаар тариалангийн газар эзэмшигч, ашиглагчид хугацаатай мэдэгдэл өгнө.
- ▶ 27.3.Мэдэгдэлд заасан хугацаанд хөрсний төлөв байдлыг сайжруулах арга хэмжээ аваагүй бол тариалангийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох шатны Засаг даргад хүргүүлнэ.
- ▶ 27.4.Энэ хуулийн 27.3-т заасан саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга хөрсний төлөв байдлыг дордуулсан иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгож Газрын тухай хуульд заасны дагуу тухайн этгээдэд мэдэгдэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- ▶ Дэвшилтэт технологи (ээлжлэн тариалалт, тэг элдэншүүлэг гэх мэт) нэвтрүүлэх ажлыг, зохион байгуулах, дэмжих
- ▶ Хөрсний бүтэц, үржил шимд эерэг нөлөө бүхий техникийн сонголтыг хийх
- ▶ Сэлгээний таримлын зах зээлийн орчинг бүрдүүлэх
- ▶ Бордоог хөрсний шинжилгээний үр дүнд үндэслэн хэрэглэх хэвшлийг тогтоох
- ▶ Хөрсний шинжилгээнд хамруулах ажлыг хэвшүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- ▶ Хөрсний шинжилгээний лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэх
- ▶ Дотоодын бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- ▶ Хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах
- ▶ Тариаланчидад хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр мэдлэг түгээх, сургалт семинар зохион байгуулах

Бордооны үйлдвэрлэлийг НЭМЭГДҮҮЛЭХ

- ▶ Багануур дүүрэгт:
 - Хоногт 60 тн Нийлмэл бордоо, органик болон эрдэс бордоо үйлдвэрлэх
- ▶ Баянчандмань суманд:
 - Хоногт 30 тн Нийлмэл бордоо, органик болон эрдэс бордоо үйлдвэрлэх

(Дээрх бордооны үйлдвэрээс гадна 4-5 үйлдвэрүүд бага хэмжээний бордоо үйлдвэрлэж байна)